

# ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2016-4 САР)


Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2016 оны 4 дүгээр сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 5,019 орон сууцны үнийг хамруулсан болно.

## ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

2016 оны 4 дүгээр сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 1.0%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 11.2%-иар тус тус буурчээ.


Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байгаа нь орон сууцны дундаж үнэ буурахад нөлөөлж байна.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



Жишээ: БЗД-ийн “Монгол” хотхонд 2015 оны 4 дүгээр сард 1 м<sup>2</sup> дундаж үнэ 1,864,000 төгрөг байсан бол 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 1,672,000 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.3%-иар буурсан байна.

## 1. Шинэ орон сууцны үнэ<sup>1</sup>


Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 2,025,000 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 6.8 хувиар тус тус буурсан байна.

<sup>1</sup> Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2016.4/


Орон сууцны дундаж үнэ	2,025,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-6.8%
Сарын өсөлтийн хувь	-0.8%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/




## 2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр<sup>2</sup>

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ<sup>3</sup> нь 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 80,000,000 төгрөг болж өмнөх сараас 0.9 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 17.0 хувиар тус тус буурсан байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2016.4/


Орон сууцны дундаж үнэ	80,000,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-17.0%
Сарын өсөлтийн хувь	-0.9%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сар,төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

<sup>2</sup> Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

<sup>3</sup> 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)